



МОНГОЛ УЛС  
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ  
ТОГТООЛ

2015 оны 07 сарын 10 өдөр

Дугаар 328

Улаанбаатар хот

“Азиапасифик пропертис” ХК-ийн үнэт  
цаасыг бүртгэлээс хасах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1, 6.2.2, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.1.10, Компанийн тухай хуулийн 23 дугаар зүйл, 2014 оны 06 дугаар тогтоолоор батлагдсан “Үнэт цаасны бүртгэлийн журам”-ын 22 дугаар зүйлийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:


1. “Азиапасифик пропертис” ХК-ийн нийтэд санал болгон гаргасан нийт 3,527,700 /гурван сая таван зуун хорин долоон мянга долоон зуу/ ширхэг хувьцааг үнэт цаасны бүртгэлээс хасахыг Үнэт цаасны зохицуулалтын газар /Т.Гандулам/, хөрөнгийн биржийн жагсаалтаас хасахыг “Монголын хөрөнгийн бирж” ХК /Д.Ангар/, үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн бүртгэлээс хасахыг “ҮЦТТХТ” ХХК /Ж.Алдаржавхлан/-д тус тус үүрэг болгосугай.

2. Компанийн хэлбэрийг өөрчлөн хязгаарлагдмал хариуцлагатай компани болох шийдвэр гарсантай холбогдуулж өөрийн эзэмшлийн хувьцааг эргүүлэн худалдан авах үнийг 2,460 /хоёр мянга дөрвөн зуун жар/ төгрөгөөр тооцон холбогдох арга хэмжээг Компанийн тухай хуулийн 54 дүгээр зүйлд заасан журмын дагуу зохион байгуулж, гүйцэтгэлийг ажлын 10 хоногт багтаан тус Хороонд тайлагнахыг “Азиапасифик пропертис” ХК /Д.Галбадрах/-д үүрэг болгосугай.

3. Шаардах эрхээ хэрэгжүүлээгүй хувьцаа эзэмшигч түүнд ногдох ногдол хувийн мөнгөн хөрөнгийг авалгүйгээр хязгаарлагдмал хариуцлагатай компанийн хувьцаа эзэмшигчээр үлдэх хүсэлтийг хэдийд ч гаргаж болох бөгөөд уг хүсэлтийг Компанийн тухай хуулийн 24.4-т заасан журмын дагуу өөрчлөн байгуулагдаж байгаа хязгаарлагдмал хариуцлагатай компанийн хувьцаа эзэмшигчээр бүртгэж авах үүргийг хэрэгжүүлэхийг “Азиапасифик пропертис” ХК / Д.Галбадрах/-д даалгасугай.

4. Энэ тогтоол батлагдсанаас хойш ажлын 10 хоногийн дотор Улсын бүртгэлийн ерөнхий газарт мэдээлэл хүргэхийг Үнэт цаасны зохицуулалтын газар /Т.Гандулам/-т, тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт шалгалтын газар /Б.Оюунцацрал/-т, олон нийтэд мэдээлэхийг Тамгын газар /П.Алтан-Од/-т тус тус даалгасугай.

ДАРГА



З.НАРАНТУЯА

000933